

УЛС ТӨР

ЦАХИЛГААНЫ ШӨНИЙН ТАРИФЫГ ХӨНГӨЛЖ, УГААТАЙ ТЭМЦЭНЭ

II нүүрт

ОНИЦЛОХ ХУУДАС

МАН-Д ИРГЭД ИТГЭЛ ҮЗҮҮЛСЭН ШИГЭЭ ХАРИУЦЛАГА ТООЦНО ГЭВ

V нүүрт

АЛБАНИЙ ХҮНИЙ ҮГ



Дугаарын **60** мөр
Сошиал медиад солиорогчдыг торгоё
Б.ДАВАА

ҮЗЭЛ БОДОЛ

TheDiplomat.com:

ХЯТАДЫН ЗЭЭЛ МОНГОЛЫН ХЯМРАЛЫН ГАРЦ БИШ

Б.ДАВАА

Монголын эдийн засгийн нөхцөл байдал, УИХ-ын даргын өмнөд хөршид хийсэн айлчлалын талаар дэлхийн зарим хэвлэл хэрхэн дүгнэн бичиж буйг "Монгол дэлхийн хэвлэлд" булангаараа тоймлон хүргэж байна.

Эдийн засгийн хямралыг шийдвэрлэж чадахгүй вэ" гэсэн гарчиг бүхий нийтлэлийг "TheDiplomat.com" сайтад Александер Бенард нийтэлжээ. Тус нийтлэлд "Энэ сарын эхээр Монгол Улсын Сангийн сайд болон Монгол банкны Ерөнхийлөгч Вашингтонд айлчилж, улсад нь тулгараад буй санхүүгийн дарамтыг хөнгөлж, Олон улсын валютын сангаас зээл авах талаарх анхны яриа хэлэлцээрийг хийсэн. Монголын талаас ОУВС-аас хэдий хэрийн зээл хүсч байгаа нь олон нийтэд хаалттай байгаа ч, 1.5 тэрбум ам.долларын зээл яригдсан гэсэн таамаг бий.

TheDiplomat.com: Хятадын мөнгө Монголын эдийн засгийн хямралыг шийдвэрлэж чадахгүйн учир

"Хятадын мөнгө яагаад Монголын

Үргэлжлэл нь III нүүрт



Ч.БАТ-ЭРДЭНЭ: ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХЯНАЛТЫН СИСТЕМД ШИЛЖИНЭ

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

МОНГОЛЫН "ХАРВАРД"-ААС СУРАЛЦАХ ЗҮЙЛС ОЛОН БАЙНА

–Монголын нүүрийг дэлхийд тахлах сургууль АШУУИС–

Н.БАТЗАЯА

Дэлхий ертөнц хөгжих тусам хүн төрөлхтөн эрх мэдэл, эд баялагаас илүү эрдэм мэдлэг, оюун ухаанаа хөгжүүлэхийг эрхэмлэдэг болжээ. Тэр хэрээр залуус чанартай боловсрол, сургалтын тав тухтай орчинг эрэлхийлж их, дээд сургуулиуд ч энэ тал дээр ихээхэн анхаарч байна. Манай улсад ч мөн ялгаагүй. Гэхдээ сүүлийн жилүүдэд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулиар овоглосон бүтээн байгуулалтын ажил олныг гайхшруулах боллоо. Шинэ сургалтын байр,



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

шинэ эмнэлэг, хичээлийн шинэ арга барил, шинэ сургалтын орчин гээд тус сургуульд

оюутнаа дээдэлсэн их үйлс өрнөж буй нь нууц биш.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

БАЙНГЫН ХОРОО

Ч.САЙХАНБИЛЭГ: Шийдвэр гаргаагүй байсан бол "Эрдэнэт"-ийн 49 хувь Оросын талд байх байсан

Ж.ОТГОН

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар "Эрдэнэт" үйлдвэртэй холбоотой гаргасан өмнөх Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох эсэх асуудлыг хэлэлцлээ. Уг асуудалтай холбогдуулж Ерөнхий сайд асан Ч.Сайханбилэг, Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирал О.Орхон зэрэг албаны хүмүүс оролцож, байнгын хорооны гишүүдийн асуултад хариулт өглөө. Хуралдааны эхэнд Сангийн сайд Б.Чойжилсүрэн "ОХУ-ын Засгийн газрын "Эрдэнэт" үйлдвэр болон "Монголросцветмет" ХХК-д эзэмшиж байсан 49 хувийн энгийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээс татгалзсан Монгол Улсын Засгийн газрын шийдвэртэй холбоотой асуудлыг судалж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг ажилласан. Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан уг ажлын хэсэг дүгнэлт гаргаж, Засгийн газарт танилцуулсан. Засгийн газрын 2016 оны аравдугаар сарын 05-ны ээлжит хуралдаанаар энэхүү дүгнэлтийг хэлэлцэж "Эрдэнэт" үйлдвэр болон "Монголросцветмет" ХХК-ийн төрийн эзэмшиж байгаа

51 хувийн өмчлөлийн харьцааг алдагдуулсан төрийн төлөөлөгч томилох, удирдамж батлах тухай Сангийн сайдын 255, төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх удирдамж батлах тухай Сангийн сайдын 256 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгохыг даалгасны дагуу эдгээр тушаалыг Сангийн сайдын 2016 оны аравдугаар сарын 06-ны өдрийн 342 дугаар тушаалаар хүчингүй болгосон. Түүнчлэн хуралдааны тэмдэглэлд "Эрдэнэт" үйлдвэр ХХК-ийн 49 хувийг худалдан авахад бүрдүүлсэн эх үүсвэрийг шалгуулах асуудлыг Монгол банканд тавьж шийдвэрлүүлэхийг Сангийн сайдад даалгасан.

Үргэлжлэл нь II нүүрт

МЭДЭГДЭЛ

Цөөн тооны хэвлэл, нийгмийн сүлжээнд "Bloomberg TV Mongolia 2013 онд 816 мянган ам.доллараар Хөгжлийн банкны сурталчилгааг хийсэн" хэмээн мэдээлж буй нь баримтаа гүйцэт нягтлаагүй, илт ташаа мэдээлэл болохыг албан ёсоор мэдэгдэж байна.

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяраар ахлуулсан ажлын хэсэг Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан танилцуулсан. Үүндээ "2012-2015 оны хооронд олон нийтэд мэдээлэл түгээх зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагад 4 тэрбум орчим төгрөг зарцуулсан байх ба "Блүүмберг ТВ"-тэй гэхэд 2013 онд 816 мянган ам.доллараар зар сурталчилгааны гэрээ байгуулсан" хэмээн дурдсаныг зарим хэвлэл, нийгмийн сүлжээнд нягтлалгүйгээр мэдээлсэн байна.

Монгол Улсыг олон улсад сурталчлах, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор "Inside Mongolia" цуврал сурталчилгаа бэлтгүүлж, нэг жилийн турш олон улсад цацуулах гэрээг 2013 онд Bloomberg LP компанитай Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банк байгуулсан. Энэ хүрээнд Bloomberg Singapore Монголын талаар сурталчилгааг хөнгөлөлттэй үнээр дэлхий дахинаа цацаж, төлбөрийг Монгол Улсын талаас Хөгжлийн банк Bloomberg LP компанид хийсэн гэдэг нь дээр дурдсан "шалгалтын дүн" гэх мэдээллүүдэд хавсаргасан англи хэл дээрх баримтаас тодорхой харагдаж байна.

Блумберг ТВ Монголиа дээрх арга хэмжээтэй холбоотой ямар нэгэн төлбөрийг Монгол Улсын Засгийн газар, Хөгжлийн банкнаас аваагүй болохыг хариуцлагатай мэдэгдэж байна.

Цаашид дээрх "ташаа" мэдээллийг ашиглан Блумберг ТВ Монголиа телевизийн нэр хүндэд халдахгүй байхыг энэхүү мэдэгдлээр дамжуулан хүсч байна.

Манай компани нь тусдаа хуулийн этгээд бөгөөд олон улсын хэмжээнд Bloomberg Television-ийн цацаж буй мэдээ мэдээлэл, гэрээ хэлэлцээр, аливаа контентийн агуулгад Блумберг ТВ Монголиа хариуцлага хүлээх ёсгүй билээ.

Bloomberg LP нь дэлхий даяар 192 төв болон төлөөлөгчийн газар бүхий 19,000 ажилтантай олон улсын байгууллага бөгөөд Сингапур дахь төв нь Азийн бүс нутгийг хариуцан ажилладаг юм.

БЛУМБЕРГ ТВ МОНГОЛИА ТЕЛЕВИЗ

Утас: +976 70102020 | Факс: +976 70102024
Хаяг: Блю Скай тауэр, 4 давхар, №403, Энхтайвны өргөн чөлөө 17, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14240, Монгол улс

Bloomberg
TV MONGOLIA

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2333.00	2348.00	ФУНТ 2809.00	2907.00
ЕВРО	2512.00	2579.00	РУБЛЬ 36.10	39.20
ИЕН	22.48	22.14	ЮАНЬ 344.00	347.60

ОНЦЛОХ ХУУДАС

Speak out



МАН-Д ИРГЭД ИТГЭЛ ҮЗҮҮЛСЭН ШИГЭЭ ХАРИУЦЛАГА ТООЦНО ГЭВ

Ж.ОТГОН

УИХ-ын болон орон нутгийн сонгуульд МАН үнэмлэхүй ялалт байгуулаад байна. Өөрөөр хэлбэл, МАН-д бүтэн итгэлээ, одоо бүрэн хөгжүүлэхийг нь харах л үлдээд байгаа юм. Тэгвэл иргэд ирэх дөрвөн жилийн хугацаанд эрх баригчдыг хэрхэн ажиллаасай гэж хүсч байгаа талаар байр суурийг нь сонслоо.

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН



И.Бямбарагчаа:
Монголыг засаглалын хямралаас гаргах хэрэгтэй

/Баянзүрх дүүргийн иргэн/
-МАН-ынхан мэргэжлийн гэх тодотголтой Засгийн газар байгуулсан. Иргэдэд мэргэжлийн байна гэдгээ ч

амлаж гарч ирсэн. Тиймээс тэдний хамгийн түрүүнд хийх ажил бол Монгол Улсыг засаглалын хямралаас гаргах хэрэгтэй. Одоо бол үндсэндээ нам төвтэй л байгаад байна. Тиймээс намуудын хуйвалдаан, нэг нь нөгөөгөө муулсан. Нэгдлийнхээ хийсэн зүйлийг нөгөө нам нь үгүй хийдэг л хүмүүс байх юм. Бараг хоёр улсын төлөөлөгчид уулзаж байгаа юм шиг л байдаг. Уг нь бүгд Монголоо

гэсэн сэтгэлтэй, эх орныхоо төлөө цохилох зурхтэй байх хэрэгтэй. Ийм л жишгийг тогтоож чадвал тэр нь МАН-ын том гавьяа болно. Одоо байгаа тогтолцоо биш байна гэдгийг сүүлийн хэдэн жил үзээд, туулаад баталчихлаа шүү дээ. Энэ бүх асуудал зөвхөн АН, МАН-аас болоод байгаа юм биш. Цоо шинэ нам гарч ирсэн ч энэ тогтолцоо өөрчлөгдөхгүй бол Монгол Улс урагшлахгүй. Энэ удаагийн

сонгуулиар УИХ-д ч орон нутгийн сонгуульд ч МАН-д иргэд итгэл үзүүлж чадлаа. МАН-ынхан УИХ-д 65 суудал авсан. Ёстой юу хийнэ тэр нь ямар нэгэн саадгүй ажил хэрэг болох зам нь нээлттэй байна. Өөрөөр хэлбэл, сөрөг хүчин нь эсэргүүцээд ажил урагшлахгүй байна гэх зовлон байхгүй. Ингэж итгэл үзүүлсэн юм чинь хариуцлага гэдэг зүйл сүүлд нь яригдаж таараа. Тиймээс МАН-ынхан АН-ынхан ингэчихсэн,

тэгчихсэн гэж гоншигнож суухын оронд ханцуйгаа шамлаад, хурдхан шиг ажилдаа орох л хэрэгтэй байна даа. Учир нь иргэд дөрвөн жилийн дараа харин ч нэг хариуцлага тооцох болно гэдгийг ухаарах цаг нь болсон.



Б.Мөнхжаргал:
Улсынхаа өрийн асуудлыг өр тавьж шийдэж болохгүй

/Хан-Уул дүүргийн иргэн/
-Улс орон эдийн засгийн хямралтай байгаа нь үнэн. Гэхдээ сүүлийн үед эрх баригчид нэг улсаас буюу

Хятад улсаас эдийн засгийн хараат болж магадгүй гэх зүйл яригдаад байгаад сэтгэл зовниж байна. Улсынхаа өрийн асуудлыг өр тавьж шийднэ гэдэг бол яав ч зөв шийдвэр биш. Хямралтай хэцүү байна гээд олон зүйлийг хасч, танаад байгаа шигээ ирэх дөрвөн жилд эдийн засгийн хувьд дэгтэй байж, дахин өр тавихгүй асуудлыг шийдэж яагаад болохгүй гэж. Өөр нэг асуудал нь улс төрд ямар нэгэн

байдлаар халаа, сэлгээ хийдэг байж болох л юм. Гэхдээ ингэж толгой дараалан аливаа төрийн байгууллагын цэвэрлэгчийг нь хүртэл ажлаас халдаг байж болохгүй. Төрийн албыг төрийн алба болгож болохгүй юм биз дээ. МАН-ын хувьд төрийн эрх авсан цагаасаа л томилгооны асуудал одоог хүртэл дуусахгүй үргэлжилж байна. Засаг төр солигддоо гээд мөрөөрөө ажлаа хийж байгаа иргэдээ гудамжинд

хөөж гаргадаг байж болохгүй. Иргэдэд амлаад байсан шигээ мэргэжлийн Засгийн газар байж, олон жил засаглаж байсан зангаргаа харуулах л хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, ийм хэцүү цаг үед эрх барьж байгаа ч гэлээ улс орноо уснаас хуурай аваад гарчихвал иргэд хэдэн үеэрээ МАН-д талархаж амьдрах л байх. Хэрвээ өөр хоорондоо хөлөө жийлцээд, идэж, уухаа гүйцэлдүүлсээр дөрвөн жилийн

үдчихвэл асуудал өөрөөр эргэх нь ойлгомжтой. Нэг үеэ бодвол монголчууд сонгууль өгч сурсан байна. Улс төрийн хариуцлага тооцоод сурчихсан байна шүү дээ.



Н.Уянга: Иргэдэд амлаж гарч ирсэн бүх зүйлээ л хийгээрэй

/Баянгол дүүргийн иргэн/
-МАН-ын мөрийн хөтөлбөр иргэн бүрт хандсан маш сайн

мөрийн хөтөлбөр байсан. Тиймээс ч иргэд дээр, дооргүй итгэл үзүүлж санал өгсөн байх. Тиймээс иргэдэд амлаж гарч ирсэн бүх зүйлээ л хийгээсэй гэж хүсч байна. Түүнээс иргэдээрээ тоглоом хийгээд байгаа ч юм шиг зүйл хийгээд байж болохгүй. Тухайлбал, "Сайн оюутан" гэдэг нэртэй сургалтын төлбөрийн зээлийг

үгүй хийгээд, "Боловсролын зээлийн сан" гэж нэрийг нь өөрчилж байх жишээтэй. Энэ мэтээр хүүхдийн тоглоом шиг зүйл хийхийн оронд дорвитой зүйл л хийх хэрэгтэй байна. Шинэ Засгийн газрын 100 хоногт миний хувьд "муу" дүн тавина. Ганц би ч биш. Монголын ард түмэн "муу" дүн тавих байх гэж

бодож байна. Гэхдээ нэгэнт УИХ-д 65 суудлыг өгчихсөн юм чинь гэж бодоод л орон нутгийн сонгуулиар ч МАН-ыг сонгосон. Тиймээс дөрвөн жилийн дараа иргэдээс "муу" дүн авахгүй байхын тулд одооноос эрчимтэй ажиллах шаардлагатай байх аа.

ард түмэн ямар нэгэн зүйл хэлээд байна гэж л ойлгох хэрэгтэй. АН гараад юм хийхгүй байна. Тиймээс МАН-ыг сонгоод үзэе гэж бодсон хэрэг. Гэтэл МАН-ынхан засгийн эрх бариад хийсэн зүйл нь хүүхдийн мөнгөнөөс эхлээд ахмадын тэтгэвэр гээд хасаагүй зүйл алга. Тиймээс ч ард иргэд цөхөрч, туйлдаж аль



О.Пүрэв: МАН энэ удаад сайн ажиллаж чадвал дараагийн удаа сонгоно

/Баянзүрх дүүргийн иргэн/
-МАН юм хийж чаддаг бол

одоо л хийх цаг хугацаа нь ирсэн байна даа. Учир нь УИХ-д 65 суудал өвч чадлаа. Орон нутгийн сонгуульд ч иргэд итгэл хүлээлгэж сонголоо. Аливаа ажлыг нь сөрөг хүчин гацаагаад байх ямар ч үндэслэл алга. Хэрвээ энэ удаад тэд улс орноо хямралаас гаргаж чадахгүй бол дараа дараагийн сонгуульд МАН дахиж засгийн

эрх барих талаар горьдох ч эрхгүй болно. Учир нь МАН-д бараг түүхэнд байгаагүй итгэл хүлээлгэж байна шүү дээ. Өмнө нь нэг удаа МАН-д бас ингэж итгэл хүлээлгэж байсан юм байна. Тэр цаг хугацаанд тэд ажиллаж чадаагүй. Энэ удаад яах юм байгаа юм. Орон нутгийн сонгуулиар иргэд санал өгөхгүй байна гэдгийг

ард түмэн ямар нэгэн зүйл хэлээд байна гэж л ойлгох хэрэгтэй. АН гараад юм хийхгүй байна. Тиймээс МАН-ыг сонгоод үзэе гэж бодсон хэрэг. Гэтэл МАН-ынхан засгийн эрх бариад хийсэн зүйл нь хүүхдийн мөнгөнөөс эхлээд ахмадын тэтгэвэр гээд хасаагүй зүйл алга. Тиймээс ч ард иргэд цөхөрч, туйлдаж аль

ч намыг сонгохыг хүсэхгүй байгаа хэрэг. Түүнээс МАН Засаг бариад сайн ажиллаж чадсан бол залуус сонгуульдаа сайн оролцох байсан. Манай залуучуудын ухамсар өндөр болсон шүү дээ. МАН энэ удаад сайн ажиллаж чадвал дараа дараагийн удаа иргэд итгэл үзүүлж сонгох л болно.



Б.Ундрах: МАН нэгэнт Засгийн эрхийг авсан юм чинь ажлаа сайн л хийх хэрэгтэй

/Сүхбаатар дүүргийн иргэн/

-Би нам бус хүн. Гэхдээ МАН нэгэнт Засгийн эрхийг авсан юм чинь ажлаа сайн л хийх хэрэгтэй. АН-ын хийсэн бүхэн муу, МАН-ын хийж байгаа бүхэн гоё гэж хэчнээн яриад цаг хугацаа дүн тавиад өгнө. Тиймээс сонгуулийн үеэр амлаж байсан шиг ажлаа сайн л хийх нь чухал. Хэрвээ дөрвөн

жилийн дараа Монгол Улс хямралгүй болчихсон, хүүхдээ харж байгаа ээжүүд цалин авдаг, хүүхэд бүр хүүхдийн мөнгө авдаг гээд асуудал бүхэн шийдэгдчихвэл сайнхан л байна. Ер нь улс орны төлөө хийж, бүтээнээ л гэж гарч ирсэн юм чинь боломж, бололцооныхоо хэрээр хийж,

бүтээх л хэрэгтэй байх даа.

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА



МОНГОЛЫН “ХАРВАРД”-ААС

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

—Монголын нүүрийг дэлхийд тахлах сургууль АШУУИС—

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Оюутнаа дээдлэх нь арга ч үгүй биз. Учир нь эмч болох хүсэлтэй мянга мянган залуус тус сургуульд суралцахын төлөө жил бүр ЭЭШ-ын оноогоороо өрсөлдөж байгаа юм чинь чанартай боловсрол, ая тухтай суралцах орчинг бүрдүүлэх нь зүйн хэрэг. Тиймээс “Монголын мэдээ” сонин 74 жилийн түүхтэй Анагаах ухааны үндэсний их сургуулиас энэ удаагийн дугаарын сурвалжлагаа бэлтгэлээ.

74 жилийн түүхийн хуудсыг эргүүлэх

Манай сурвалжлах хэсгийг тус сургуулийн хаалгаар ормогц л эмнэлгийн цагаан халаатгай оюутан залуус бужигнаж байлаа. Сурах чин хүсэл эрмэлзлээр жигүүрлэгдсэн оюутны өргөөнд орж ирсэн нь үүднээсээ эхлээд л мэдрэгдэж байв. Бид юун түрүүнд тус сургуулийн Боловсролын асуудал эрхэлсэн тэргүүн дэд захирал Н.Сүмбэрзүлтай уулзаж, сурвалжлага хийх тухайгаа тайлбарласан юм. Тэрбээр бидэнд сургуулийнхаа түүхээс эхлээд одоо хийж хэрэгжүүлж буй ажил болон сургуулиа танилцуулсан юм. 2024 онд Ази, номхон далайн шилдэг 100 сургуулийн нэг болох зорилготой Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн туурь тэртээ 74 жилийн өмнө тавигджээ. 1942 онд Монгол Улсын их сургуулийн дэргэд Хүн эмнэлгийн факультет нэртэйгээр байгуулагдаж, 1947 онд анхны төгсөлтөөрөө 14 их эмчийг бэлтгэн гаргасан байна. МУИС-ийн Хүн эмнэлгийн факультетийн суурин дээр үндэслэн 20 гаруй тэнхим, 65 багш, 800 гаруй оюутантайгаар Улсын их сургуулиас туурга тусгаарлан, 1961 онд бие даасан Анагаах ухааны дээд сургууль болжээ. Эмнэлгийн дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тухайн цаг үеийн бодлогоор шинээр элсэгчдийг клиникийн эмнэлэгт асрагчаар, тус сургууль төгсөгчдийг туслах эмчээр буюу субординатораар нэг жил ажиллуулж, эмнэлгийн практик үйл ажиллагааны анхны мэдэгдэхүүнийг эзэмшүүлж байсан байна. Үүний дара БНМАУ-ын Засгийн газраас тогтоосны дагуу өндөр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, үндэсний шинжлэх ухааны чадавхийг дээшлүүлэн, улс орны ирээдүйн хөгжилд дээд сургуулиудын оролцоог нэмэгдүүлэх явдал нэн чухал болж байгааг харгалзан их, дээд сургуулиудыг цаашид сургалт, эрдэм шинжилгээний байгууллага болгох зорилгоор Анагаах ухааны дээд сургуулийг 1991 онд их сургууль, 2003 онд Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль болгон өргөжүүлсэн аж. Харин 2014 онд ЭМШУИС-ийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний



үндсэн дээр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль болж, олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн эрдэм шинжилгээ, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг, үндэсний тэргүүлэх, Номхон далайн баруун эргийн бүсийн анагаах ухааны шилдэг 100 их сургуулийн, нэг болох зорилго тавин ажиллаж байгаа ажээ. Тус сургуульд одоогийн байдлаар 21 мэргэжлээр 12000 оюутан, 713 резидент эмч, төрөлжсөн нарийн мэргэжлээр 110, сувилахуйн чиглэлээр 11, магистрант 694, докторант 161 суралцаж байна. Мөн жилдээ төрөлжсөн нарийн мэргэжил болон мэргэжил дээшлүүлэх кредит сургалтад нийт 834 эмч хамрагдан мэргэжил мэдлэгээ дээшлүүлж, байгуулагдсан цагаасаа хойш нийт 16771 хүний их эмчийг бэлтгэн гаргажээ. Ийнхүү Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль гэх том айлын түүхтэй танилцсаны дараа Н.Сүмбэрзүл тэргүүн дэд захирал сургуулийнхаа орчинг бидэнд танилцуулсан.

Сургалтын орчин
мэргэжилдээ дуртай
болоход нөлөөлсөн гэв

Бидний очсон эхний газар бол тус сургуулийн брэнд болсон оюутны эко цогцолбор. Хуучин машины гарааш байсан хэсэгхэн газрыг ашиглан оюутан чөлөөт цагаа өнгөрүүлэхэд тохиромжтой эко цогцолбор болгон засварласан нь энэ аж. “Би ээжийнхээ зөвлөснөөр эмч болсон” хэмээн ярих хүүг Х.Мөнх-Эрдэнэ гэдэг бөгөөд тус сургуулийн Хүний их эмчийн IV дүгээр курсийн оюутан. Хэн нэгний хүсэлтээр өөрийн ирээдүйн мэргэжлээ сонгосон ч одоо эзэмшиж буй мэргэжилдээ дуртай болсон гэнэ. Харин түүний санаа нийнхүү өөрчлөгдөхөд тавин ажиллаж байгаа ажээ. Тус сургуульд одоогийн байдлаар 21 мэргэжлээр 12000 оюутан, 713 резидент эмч, төрөлжсөн нарийн мэргэжлээр 110, сувилахуйн чиглэлээр 11, магистрант 694, докторант 161 суралцаж байна. Мөн жилдээ төрөлжсөн нарийн мэргэжил болон мэргэжил дээшлүүлэх кредит сургалтад нийт 834 эмч хамрагдан мэргэжил мэдлэгээ дээшлүүлж, байгуулагдсан цагаасаа хойш нийт 16771 хүний их эмчийг бэлтгэн гаргажээ. Ийнхүү Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль гэх том айлын түүхтэй танилцсаны дараа Н.Сүмбэрзүл тэргүүн дэд захирал сургуулийнхаа орчинг бидэнд танилцуулсан.

Сургалтын орчин
мэргэжилдээ дуртай
болоход нөлөөлсөн гэв

Бидний очсон эхний газар бол тус сургуулийн брэнд болсон оюутны эко цогцолбор. Хуучин машины гарааш байсан хэсэгхэн газрыг ашиглан оюутан чөлөөт цагаа өнгөрүүлэхэд тохиромжтой эко цогцолбор болгон засварласан нь энэ аж. “Би ээжийнхээ зөвлөснөөр эмч болсон” хэмээн ярих хүүг Х.Мөнх-Эрдэнэ гэдэг бөгөөд тус сургуулийн Хүний их эмчийн IV дүгээр курсийн оюутан. Хэн нэгний хүсэлтээр өөрийн ирээдүйн мэргэжлээ сонгосон ч одоо эзэмшиж буй мэргэжилдээ дуртай болсон гэнэ. Харин түүний санаа нийнхүү өөрчлөгдөхөд тавин ажиллаж байгаа ажээ. Тус сургуульд одоогийн байдлаар 21 мэргэжлээр 12000 оюутан, 713 резидент эмч, төрөлжсөн нарийн мэргэжлээр 110, сувилахуйн чиглэлээр 11, магистрант 694, докторант 161 суралцаж байна. Мөн жилдээ төрөлжсөн нарийн мэргэжил болон мэргэжил дээшлүүлэх кредит сургалтад нийт 834 эмч хамрагдан мэргэжил мэдлэгээ дээшлүүлж, байгуулагдсан цагаасаа хойш нийт 16771 хүний их эмчийг бэлтгэн гаргажээ. Ийнхүү Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль гэх том айлын түүхтэй танилцсаны дараа Н.Сүмбэрзүл тэргүүн дэд захирал сургуулийнхаа орчинг бидэнд танилцуулсан.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.6, 34.7 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн дараах аж ахуйн нэгжийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 89 дүгээр шийдвэрээр цуцалсныг мэдэгдэж байна.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	XV-013941	2008.07.28	Дорноговь	Сайншанд	Цав	Кратон ХХК
2	XV-013947	2008.07.31	Төв	Борнуур	Харганы ам	Итгэлтхүлэг ХХК
3	XV-015044	2009.08.03	Дорноговь	Сайхандулаан	Сухайт уул	Санчуан ривар ХХК
4	XV-017859	2015.08.05	Баянхонгор	Бөмбөгөр	Баян	Грийтвишн ХХК
5	XV-013111	2007.12.26	Өмнөговь	Номгон	Номгон-1	Твенжинсанжо ХХК
6	XV-013979	2008.08.07	Дорноговь	Хатанбулаг	Баянгийн овоо-2	Орчлон-Орд ХХК
7	XV-013978	2008.08.07	Дорноговь	Хатанбулаг	Баянгийн овоо-3	Орчлон-Орд ХХК

8	XV-015061	2009.08.10	Ховд	Булган	Очирын булаг	Вестерминэкс ХХК
9	XV-018968	2015.08.10	Баян-Өлгий	Ногооннуур	Бага дулуун хар	ДГАГ майнинг ХХК
10	XV-018792	2015.08.10	Говь-Алтай	Эрдэнэ	Их	Готикголд ХХК
11	XV-018965	2015.08.10	Баян-Өлгий	Ногооннуур	Баклык	ДГАГ майнинг ХХК
12	MV-003596	2001.08.10	Дорноговь	Айраг	Дүлий	Монголросцветмет ХХК
13	XV-013991	2008.08.12	Дорноговь	Сайншанд, Сайхандулаан	Түшлэг	Тэнгритерра ресурс ХХК
14	XV-015071	2009.08.17	Завхан	Алдархаан, Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Яруу	Залаа уул	Тэнгритерра ресурс ХХК
15	MV-017105	2012.08.17	Сүхбаатар	Эрдэнэцагаан	Баянцогт	Сидакуангей ХХК
16	MV-000158	1995.08.18	Дорноговь	Иххэт	Хашаат худаг	Чандмань-Илч ХХК
17	XV-014026	2008.08.18	Хөвсгөл	Арбулаг, Бүрэнтогтох	Буянт	Эм Жи Ти Жи ХХК
18	XV-017994	2015.08.19	Говь-Алтай	Жаргалан	Орд	Анлимитед-Айдеа ХХК
19	XV-014042	2008.08.20	Сэлэнгэ	Баянгол	171-р км	Итгэлтхүлэг ХХК

АМГТГ-ЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

тусгах нөхцөлийг бүрдүүлсэн аж. Харин цогцолборын голд усан оргилуур, хананы хоёр талаар кофе шоп, номын дэлгүүр гэх мэчлэн оюутны амралт чөлөөт цагаа өнгөрүүлэхэд зориулсан олон зүйлийг байгуулжээ. Нийт 1350 ам.метр талбай бүхий эко цогцолборт оюутны амьдрал буцаддаг гэхэд болно. Энд оюутан бүр хичээлийнхээ чөлөөт цагаар ирж, халуун кофе, цай, хөнгөн зуус идэнгээ найзуудтайгаа уулзаж хичээлийнхээ талаархи сонирхолтой яриаг өрнүүлдэг. Тэр бүү хэл өөрсдийн хүсэл сонирхлоор нэгдсэн клубын залуус ч энд уулздаг байна. Тус сургуульд нийт 60 клуб байдгаас 40 гаруй нь байнгын идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг аж. Мөн эко цогцолборын хоёр давхрын зүүн хэсэгт сургуулийнхаа музейг байгуулжээ. Музейд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн түүхийн дурсгалт зүйлс, үе үеийн төгсөгчид, эрдэмтэн, багш нар, баярын бичиг, диплом, бичгийн машин болон одоогоос 20-50 жилийн өмнө сургалтад ашиглаж байсан эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг байрлуулжээ. Харин музейн эсрэг талын хэсэгт оюутнууд хичээлээ хийх аж. Энэ хэсэгт оюутнууд даалгавраа хийхээс

гадаадын их, дээд сургуульд очсон юм шиг л сэтгэгдэл төрж байлаа. Оюутнууд нь нөүтбүүк, ном дэвтэрээ дэлгээд хүссэн газраа чөлөөтэй суугаад бие даан хичээлээ давтаж буй дүр төрх гадаадын олон кинон дээр гардаг. Яг л тийм орчинд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн оюутнууд суралцах аж. Ийм орчинд суралцаж байгаа оюутнууд сургуульдаа хайртай, дургтай байхгүй гээд ч яах юм билээ. Хичээллэх танхим, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар гээд бүх л зүйлийг сургууль дотроо бүрдүүлж чадсан оюутнуудын талархлыг ихэд хүлээжээ. Энэхүү цогцолбор байгуулагдсанаар оюутнуудын бие даан хичээллэх чадвар 70 хувиар нэмэгдсэн байна.

Олон улсын стандартад нийцсэн номын санг байгуулжээ

Бидний сонирхсон дараагийн газар бол тус сургуулийн номын сан. Орчин үеийн жишигт нийцэхүйц долоон давхар номын санг мөн л суралцагчиддаа зориулан байгуулжээ. Тус номын сангийн нэгдүгээр давхарт ховор номын танхим, хоёрдугаар давхарт уншлагын танхим,



суралцах зүйлс олон байна



...Өнгөрсөн жил багш нарын судалгаа, шинжилгээний ажилд 500 сая төгрөг төлөвлөсөн бол энэ хичээлийн жилд тэрбум төгрөгийн үнэлэмжтэй грандыг зарлажээ. Тус сургуулийн гарааны компаниудаас хамгийн амжилттай яваа нь "Өжин мед" үр шилжүүлэн суулгах төв, хелико бактерийн оношлуур үйлдвэрлэдэг компаниуд гэнэ...

гадна бие даан нэмэлт зүйлсийг судлах боломжтой гэнэ. Эко цогцолборын хоёрдугаар давхар чимээ багатай учраас хичээлээ хийхэд илүү тохиромжтой гэдгийг ч оюутнууд онцолж байлаа. Энд бид Б.Сэлэнгэтэй хэсэг ярилцсан. Тэрбээр "Би сургуулиараа их бахархдаг. Бидний сурах орчинг маш сайхан бүрдүүлсэн. Ялангуяа Г.Батбаатар захирлын үеэс сургуульд маш их бүтээн байгуулалтын ажил явагдсан. Эко цогцолбор, номын сан гээд дурдах зүйл олон бий. Би эко цогцолборын хоёрдугаар давхарт хичээлээ хийх их дургтай. Энд чимээ багатай байдаг. Ер нь хичээлээ хийе гэвэл хоёрдугаар давхарт, амарья гэвэл нэгдүгээр давхарт очдог" гэв. Тус сургуулийн эко цогцолбороор ороход

гурвдугаар давхарт төгсөгчдийн десертац, судалгааны бүтээлийн танхим байрладаг. Тодруулбал, танхим бүрийг чөлөөт уншлага, тогтмол хэвлэл, интернэт номын сан, гадаад уншлага, эрдэм шинжилгээний номын хэмээн ангилжээ. Номын сангийн орчин маш цэвэрхэн байх бөгөөд гадуур хувцастайгаа орж болохгүй гэх дүрэм үйлчилнэ. Тиймээс оюутнууд номын сангийн гадна талд байрлах хувцасны шүүгээнд хувцсаа хийж ордог байна. Оюутны хувцсаа хийх хэсэг давхар бүрт байгаа гэдгийг Н.Сүмбэрзул дэд захирал онцолсон. Тус номын сан нь 120 мянга орчим ном, 850 гаруй суудал бүхий зургаан уншлагийн танхимтай. Мөн эрдэм шинжилгээний танхимыг анагаахын чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэд болон мастер, доктороор суралцагчдад зориулсан байна. Харин 4-7 дугаар давхарт оюутнуудад зориулсан үр чадварын өрөөнүүд байрлана. Тухайлбал, уламжлалт анагаах ухаан, эх барих, чих хамар хоолойн гэх мэчлэн мэргэшсэн кабинетэд оюутнууд дадлагдаж байгаа. Тус өрөөнүүдийг тухайн мэргэжилд холбогдолтой зориулалтын багаж хэрэгслээр бүрэн хангасан гэнэ. Чих хамар хоолойн үр чадварын өрөөнд гэхэд чихний бүтцийг нарийн харуулсан үзүүлэн, дуран, гэх мэчлэн хичээлд ашиглахад зориулсан багаж, төхөөрөмжийг байрлуулжээ. Мөн түргэн тусламжийн үр чадварын өрөөнд манекэн байх бөгөөд багш хичээл орохдоо компьютерийн тусламжтайгаар өвчний түүхийг өгдөг гэнэ. Жишээлбэл, тухайн өвчний даралт, цус алдалт, биений байдал гэх мэчлэн өвчний түүхийг зохионо. Харин суралцагч өвчтөнд шаардлагатай арга хэмжээг авдаг аж. Хэрэв зөв арга хэмжээ авсан бол өвчтөн зүгээр болж буй мэдээлэл компьютерийн дэлгэц дээр гарч ирдэг гэнэ. Энэ мэчлэн сургалтын амьд орчинг бүрдүүлж, хичээлийг сонирхолтой явуулах

бүрэн боломжийг тус сургуулийн захиргаанаас хангаж чаджээ.

Багш нараа дэмжиж, гарааны компани байгуулав

Хий хоосон том зүйлийг ярих хүн өнөө үед олширсон. Тэгвэл Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн хамт олон тавьсан зорилгодоо хэрхэн хүрдгийг яруу тодоор харуулж байна гэхэд хилсдэхгүй биз. Үнэхээр хийж бүтээсэн ажил нь бидний нүдэн дээр ил байв. Тус сургуулиар зочилсон хэн бүхэн суралцах орчинг өөрчилж болдог юм байна гэсэн санаашралтай басхүү уулга алдахгүйгээр гарахгүй болжээ. Монгол Улсын хэмжээнд ажиллаж буй эмч, сувилагч нарын 90 гаруй хувийг бэлтгэдэг уг сургууль сурах орчноо сайжруулах, сургалтын хөтөлбөрөө шинэчлэх, багш нараа хөгжүүлэх гэсэн гурван зүйлд анхаарал хандуулан ажилладаг байна. Мөн дэлхийн топ 500 их сургуульд докторын зэрэг хамгаалсан 70 багш ажилладаг бөгөөд нийт 1000 гаруй ажиллагсадтай өнөр өтгөн айл аж. Түүнчлэн багш нараа хөгжүүлэхийн тулд судалгаа, шинжилгээний ажлыг нь дэмжин 2015 оноос эхлэн гранд зарлажээ. Ингэснээр тус сургуулийн багш нар гарааны компани байгуулж, олон төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд гаргаж эхэлсэн байна. Өнгөрсөн жил багш нарын судалгаа, шинжилгээний ажилд 500 сая төгрөг төлөвлөсөн бол энэ хичээлийн жилд тэрбум төгрөгийн үнэлэмжтэй грандыг зарлажээ. Тус сургуулийн гарааны компаниудаас хамгийн амжилттай яваа нь "Өжин мед" үр шилжүүлэн суулгах төв, хелико бактерийн оношлуур үйлдвэрлэдэг компани гэнэ. Энэ мэчлэн багш нараа хөгжүүлсэн олон ажлыг хийж хэрэгжүүлжээ. Анагаахын шинжлэх ухааны сургуулийн хэрэгжүүлсэн, бүтээн

байгуулсан ажлын нэгээхэн хэсэгтэй танилцахад ийм байна. Үүнээс гадна тус сургуулийн нэрээр овоглосон ажлууд олон. Тухайлбал, "Эрхэс" эмнэлэг, олон улсын Сайбер их сургууль, оюутанд зориулсан тэтгэлэг гээд дурдаад байвал олон зүйл бий. Сургалтын тав тухтай орчин, чанартай боловсрол, багш, сурагчдын нийгмийн асуудлыг тэргүүнд тавин ажиллаж буй тус сургуулийн хийж хэрэгжүүлж буй ажлаас бусад сургуунд ч үлгэр жишээ авахаар зүйл олон

аж. Ямартай ч тус сургуулийн үйл ажиллагаатай танилцаж байхад гадаадын их, дээд сургуулиудтай өрсөлдөхүйц хэмжээний сургууль манай улсад бий болж байгаа нь мэдрэгдэж байлаа. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийг Монголын Харворд гээд хэлчихэд үнэнээс хол зөрөхгүй биз. Манай улсад энэ хэмжээний сургалттай, оюутан сурагчдынхаа нийгмийн асуудалд анхаарал хандуулж, сурах орчинг нь сайжруулах гэж хичээдэг сургууль ховор. Ялангуяа улсын

сургуулиудын дунд, Өөрсдийн нөөц боломжоор санхүүжилт бий болгохын оронд улсаас жил бүр олгодог төсвөөр ойр зуурхан засвар хийгээд хичээлийн шинэ жилтэй золгодог нь хэн бүхний нүдэнд илхэн. Гарааны компани байгуулж, түүнийхээ орлогоос тодорхой хувийг сургуульдаа зарцуулдаг тус сургуулийн хөгжлийн бодлогоос суралцах зүйл их аж. Тиймээс ч Монголын Харвард ад суралцаж байгаа оюутан залуус сурч боловсрох өрнүүн хүсэлд автахгүй байх ч арга үгүй биз.

“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

2016 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

"Багануур" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар "Эрдэнэс Монгол" ХХК-ийн хурлын танхимд хуралдаж, дараах асуудлыг хэлэлцэнэ.

- 1) Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.
- 2) Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацааг дуусгавар болгох, гишүүдийг шинээр томилох тухай
- 3) Нэмж гаргах үнэт цаасыг бүртгэлээс хассантай холбогдуулан авах арга хэмжээний тухай.

Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөр, Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 11 дүгээр сарын 14-ний өдрийн 13:00 цагаар тасалбар болгоно.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын холбогдох материалтай 2016 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн "Багануур" ХК-ийн төлөөлөгчийн газар, харьяа брокер диллерийн компани дээрээ ирж танилцан хуралдаа идэвхтэй оролцоно уу.

Хурал хуралдах газрын хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар "Эрдэнэс Монгол" ХХК-ийн хурлын танхим

Лавлах утас: 458940,

Хурал зохион байгуулах комиссын дарга: Б.Ганбаатар, утас: 99815690, ganbaatar@erdenesmongol.mn

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
Д.Ганчимэг - "Багануур" ХК-ийн Хуулийн зөвлөх, 88082547
С.Одончимэг - "Багануур" ХК-ийн Хэвлэл мэдээллийн ажилтан, 99044373,
С.Батболд - "Багануур-Илч" ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 99002742

